



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭГ 2026 ОНД САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 оны 03 дугаар сарын 09

Дархан-Уул аймаг
Хэрэгжүүлэгч Хяналт тавих
Хэрэгжүүлэх хугацаа субъект

ГАДААД ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч	Хяналт тавих субъект
1.	Байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар дахь үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны мэдээлэл ил тод эсэхэд улирал тутам дүн шинжилгээ хийх, дутуу мэдээллүүдийг байршуулж хэвшүүлэх;	Хувь	80%	2026.03.01- 2026.12.31	Мал амьтны эрүүл мэнд, хяналт хорио цээр, баталгаажуу лалтын хэлтсийн мэргэжилтэн	Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга
2.	Байгууллагаас хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчинд түгээх, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах;	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд түгээсэн мэдээллийн тоо, зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгийн тоо	- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр жилд 2-оос доошгүй мэдээлэл гарсан байна. - 2-оос доошгүй удаа нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан байна. - Олон нийтийн цахим сүлжээ /фейсбүүк, ютүб, твиттер, инстаграмм, цахим хуудас/ зэрэгт тухай бүр мэдээлэл байршуулсан байх.	2026.03.01- 2026.12.31	Улсын байцаагч нар, Мэргэжилтэ нүүд	Мал амьтны эрүүл мэнд, хяналт хорио цээрийн хэлтсийн дарга

3.	Тухайн орон нутгаас төрөн гарсан, эсвэл олны танил хүмүүсээр байгууллагын үйл ажиллагааг сурталчлуулсан зэрэг бичлэг, сэтгэгдэл, пост мэдээлэл цахим системд оруулах зэрэг нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах;	Хамтран ажилласан олны танил хүний тоо, хийлгэсэн сурталчилгааны тоо	Олны танил 2-аас доошгүй хүмүүсээр байгууллагын сурталчилгааг хийлгэсэн байх.	2026.03.01-2026.09.30	Захиргаа санхүүгийн хэлтэс	Газрын дарга
4.	Байгууллагын албан хаагчдад иргэдтэй хүндэтгэлтэй харилцах, ажлын цагийг баримтлах, ёс зүйн зөрчил гаргахгүй байх, иргэний гаргасан хүсэлтэд дурдсан асуудлыг бүрэн дүүрэн тайлбарлаж өгч байх, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автахгүй байх, бусдад хууль бус давуу байдал олгохгүй байх, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулахгүй байх, бусдаас шан харамж авахгүй байх, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэхгүй байх, хувийн ашиг сонирхол гаргахгүй байх талаар баталгаа гаргуулах, эдгээр зөрчлийг гаргахгүй байхад чиглэсэн соён гэгээрүүлэх, сургалт зохион байгуулах;	- Нийт албан хаагчдын баталгаа гаргасан байдал /хувиар/. - Сургалтын тоо.	- Бүх албан хаагчдаар баталгаа гаргуулсан байх. - 2-оос багагүй сургалт.	2026.03.01-2026.09.30	Захиргаа санхүүгийн хэлтэс	Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга
5.	Тухайн байгууллагаас иргэд, олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний хугацаа, чанар, хүртээмжид дүн шинжилгээ хийж, хүнд суртал, чирэгдэл үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, арилгахад чиглэсэн арга хэмжээ авах;	Хийсэн дүн шинжилгээ, үр дүнд суурилан зохион байгуулсан арга хэмжээний тоо	-Дүн шинжилгээ, ажлын байрны зураглал хийсэн байх. - Үр дүнгээс хамааран хүнд суртал, чирэгдлийг бууруулах арга хэмжээ авсан байх.	2026.03.01-2026.10.31	Захиргаа санхүүгийн хэлтэс	Газрын дарга
6.	Албан хаагчдаас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар санал асуулга авч, түүний үр дүнд үндэслэн холбогдох арга хэмжээ авах;	Авсан судалгаа, хамрагдсан албан хаагчийн тоо, үр дүнд үндэслэн зохион байгуулсан арга хэмжээний тоо	-Албан хаагчдыг санал асуулгад бүрэн хамруулсан байх; - Үр дүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх;	2026.03.01-2026.09.30	Захиргаа санхүүгийн хэлтэс	Газрын дарга

7.	Үйл ажиллагааны болон мал эмнэлгийн арга хэмжээний батлагдсан төсвийн мэдээллийг цахим системд тухай бүрд мэдээлж ажиллах,	Мэдээллийн тоо	Шилэн данс цахим системд мэдээллийг бүрэн оруулсан байна.	2026.03.01-2026.06.30	Ахлах нягтлан бодогч	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
ДОТООД ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР						
8.	Тухайн байгууллагын албан хаагчид албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах нь авлигын гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй үйлдэл болох талаар нийт албан хаагчдад сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах;	Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо	1 сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байх.	2026.03.01-2026.09.30	Мал амьтны эрүүл мэнд, хяналт хорио цээр, баталгаажуулалтын хэлтсийн мэргэжилтэн	Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга
9.	Нээлттэй мэдээллийн систем(shilen.gov.mn)-д байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг тухай бүрд мэдээлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод, шуурхай байдлыг хангах,	Мэдээллийн тоо, үнэлгээ	Цахим системд мэдээллийг бүрэн оруулсан байна.	2026.03.01-2026.09.30	Захиргаа санхүүгийн хэлтэс	Газрын дарга
10.	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хийх ажлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах	Төлөвлөгөө батлагдсан байдал. Тийм бол "1", үгүй бол "0"	Дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөөг баталж, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх	2026.03.01-2026.12.31	Мал амьтны эрүүл мэнд, хяналт хорио цээр, баталгаажуулалтын хэлтсийн мэргэжилтэн	Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга
БОДЛОГОД ОРОЛЦОГЧДЫН ҮНЭЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР						

11.	Байгууллагын удирдах тушаалтнаас нийт албан хаагчдад шуударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэсэн албан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, албан хаагчдаас гарсан авлигын эсрэг санал санаачилгыг дэмжин ажиллах;	Зохин байгуулсан уулзалт, хэлэлцүүлгийн тоо	Нийт албан хаагчдад шуударга байдлын үнэлгээг сайжруулахад чиглэсэн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулагдсан байх.	2026.03.01-2026.06.30	Захиргаа санхүүгийн хэлтэс	Газрын дарга
12.	Шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр албан хаагчдаас асуумж судалгаа авах	Судалгааг авч нэгтгэсэн байна.	Асуумж судалгааны дүнг нэгтгэн газрын даргын дэргэдэх зөвлөлд танилцуулах,	2026.03.01-2026.10.30	Захиргаа санхүүгийн хэлтэс	Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА

А.СУВДАА

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:

МЭРГЭЖИЛТЭН

Н.БААСАНСҮРЭН